

Хятад-Монгол-Орос гурван орны эрдэмтдийн V форум “Зүүн Хойд Ази дахь хамтын ажиллагааны ирээдүй”

БНХАУ-ын Нийгмийн ШУА-ийн Ази Номхон далай, стратеги судлалын хүрээлэнгээс 2014 оны 5-р сарын 30-нд Бээжин хотноо “Зүүн хойд Азийн хамтын ажиллагааны ирээдүйн төлөв” сэдвээр Хятад, Монгол, Орос гурван орны эрдэмтдийн V форумыг зохион байгууллаа. Уг форумд Монголын талаас Монголын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D) Д.Шүрхүү “Зүүн хойд Азийн эрчим хүчний аюулгүй байдал ба Монгол, Орос, Хятад гурван орны хамтын ажиллагаа”, эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D) А.Нямдолжин “Монгол Улс бол Европ ба Зүүн хойд Азийг холбосон хуурай замын гүүр болох нь”, Хятад судлалын салбарын эрхлэгч, доктор (Ph.D) Н.Ариунгуа “Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн гадаад хүчин зүйл: Хятад ба Орос”, МУИС-ийн Олон улсын харилцаа, төрийн удирдлагын сургуулийн захирал профессор С.Баттулга, профессор Ж.Баттөр “Зүүн хойд Азийн тэргүүлэх орнуудын бүс нутгийн хамтын ажиллагааны шинэ санаачилга” сэдвээр тус тус илтгэл тавьж хэлэлцүүлэн санал солилцлоо. Хятадын талаас БНХАУ-ын Нийгмийн ШУА-ийн Ази Номхон далай, стратеги судлалын хүрээлэн, Өвөр Монголын их сургуулийн Хөрш орон судлалын хүрээлэн, Өвөр Монголын Нийгмийн ШУА-ийн Монгол, Орос судлалын хүрээлэн, Хар мөрөн мужийн Зүүн хойд Ази судлалын хүрээлэн, Гириний Их сургуулийн Зүүн хойд Ази судлалын хүрээлэн, Оросын талаас ОХУ-ын Дорно дахины хүрээлэнгийн Солонгос, Монгол судлалын секторын эрхлэгч А.В.Воронцов, доктор В.В.Грайворонский, доктор Е.В.Бойкова зэрэг 40 гаруй эрдэмтэн судлаач нар оролцож нийт 14 илтгэл хэлэлцүүлэв.

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Хятад-Монгол-Орос гурван орны эрдэмтдийн V форумын талаархи мэдээ Хятадын “Жэньмин вань сайт”-нд тавигдсан¹. Тус мэдээнд Жэньминжибао сонины сурвалжлагч Сюэ Вэнь Хятадын нийгмийн шинжлэх ухааны Ази Номхон далай болон Дэлхийн стратегй судлалын хүрээлэнгийн захирал Ли Сянь Яны тус форумыг нээж хэлсэн үгийг онцолжээ. Доктор Ли Сянь Ян хэлсэн үгэндээ Зүүн хойт Ази нь Хятад, Монгол, Орос гурван орны хамтын ажиллагааны чухал бүс нутаг бөгөөд энэ бүс нь Монгол Улсын хувьд худалдаа, хөрөнгө оруулалтын түнш байхаасаа гадна ирээдүйд далай руу гарах гарц болох боломжтой гээд Монгол улсын гадаадад нээлттэй байдал нь улам бүр өргөжин нэмэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд Зүүн хойт Азийн улс орнуудын хамтын ажиллагаа нь Монгол улсын хувьд чухал ач холбогдолтойг тэмдэглэсэн. ОХУ-ын хувьд Украины хэрэг явдлын нөлөөгөөр Оросын Зүүн болон Азийн чиглэл дэх стратеги шинэ шатанд шилжин чухамхүү Зүүн хойт Ази нь түүний Зүүн чиглэлийн стратегийн чухал бааз суурь нь болох нь гарцаагүй юм гэжээ. Мөн 2013 онд Хятадын дарга Си Зинпины дэвшүүлсэн “нэг зам-нэг бүс нутаг” гэсэн урианы олон талын ач холбогдлыг дурдахын зэрэгцээ “Торгоны замын дайран өнгөрөх эдийн засгийн энэ бүс нутаг нь гурван орны хамтын ажиллагааны шинэ боломж байх магадлалтайг цохон тэмдэглээд бүс нутаг дахь гурван талт хамтын ажиллагаа нь ямар түвшин, ямар хүрээнд явагдах нь бидний хамтын оюун ухаан, хүсэл эрмэлзлэлээс ихээхэн хамаарна мөн гурван улсын эрдэмтэд Бээжинд чуулж энэ тухай хэлэлцэж байгаа нь цаг үеэ олсон үйл явдал болохыг тэмдэглэснийг эшилжээ. Сурвалжлагч тус форум дээр тавигдсан БНХАУ-ын Нийгмийн ШУА-ийн Ази Номхон далай, стратеги судлалын хүрээлэнгийн судлаач Пяо Зянь И-ийн “Зүүн хойт Азийн бүс нутгийн хамтын ажиллагаан дахь Хятад, Монгол, Оросын үйл ажиллагааг зохицуулах асуудалд”, Монголын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D) Д.Шүрхүүгийн “Зүүн хойд Азийн эрчим хүчний аюулгүй байдал ба Монгол, Орос, Хятад гурван орны хамтын ажиллагаа”, мөн тус хүрээлэнгийн судлаач доктор (Ph.D) Н.Ариунгуагийн “Монгол Улсын эдийн засгийн

¹ <http://world.people.com.cn/n/2014/0531/c157278-25089552.html>

ОЛОН УЛС СУДЛАЛ

хөгжлийн гадаад хүчин зүйл: Хятад ба Орос”, ОХУ-ын Дорно дахины хүрээлэнгийн Солонгос, Монгол судлалын секторын эрхлэгч А.В.Воронцовын “Зүүн хойд Азийн бүс нутаг дахь хамтын ажиллагаа: хүрсэн үр дүн, бэрхшээл, ирээдүй”, мөн тус хүрээлэнгийн судлаач доктор В.В.Грайворонскийгийн “Орос-Монгол, Хятад: найрамдалт, найрсаг хөршийн харилцаа, хамтын ажиллагаанаас стратегийн түншлэл рүү” зэрэг илтгэлд өөр өөр өнцгөөс Хятад, Монгол, Орос гурван орны болон Зүүн хойд Азийн бүс нутаг дахь хамтын ажиллагааны байдал, оршиж буй асуудлууд болон ирээдүйг гүнзгий шинжлэн дүгнэсэн нь хуралд оролцогчдын зүгээс өндөр үнэлэлт авсан тухай дурджээ.

Тус мэдээнд Монгол Улсад элчин сайдаар ажиллаж байсан элчин сайд Хуан Зякуй оролцсон болон түүний хэлсэн үгийг мөн дурджээ. Тэрээр хэлэхдээ Хятад, Монгол, Орос улсууд нь нийтлэг эрх ашигтай, байгалийн баялаг нь хоорондоо ойр зайнд байрлалтай, гурван улсын хооронд шийдвэрлэгдээгүй том асуудлууд байхгүйг тэмдэглээд гурван улсын хоорондын хамтын ажиллагаа олон талт болж байгаа хандлага нь хамтын ажиллагааг улам эрчимжүүлж улмаар аажим аажмаар өмнөд Солонгос, хойд Солонгосыг татан оролцуулж Зүүн хойд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааг нэгтгэн хамтдаа хожих зорилтонд хүрэх боломжтой болон мөн тус бүс нутгийн аюулгүй байдлыг богино хугацаанд шийдвэрлэх бэрхшээлтэй байгаа өнөөгийн нөхцөлд гурван улс хамтын ажиллагаагаа бэхжүүлэн бүс нутгийн хамтын ажиллагааг урагшлуулах нь тэдгээрийн язгуур эрх ашиг, ирээдүйд нь ач холбогдолтой талаар ярьсныг мөн эшлэн дурджээ².

Гурван улсын эрдэмтдийн форум нь Монгол, Орос, Хятадын хамтын ажиллагааны бас нэг чухал хэлбэр бөгөөд одоогийн байдлаар 2008 онд анх ШУА-ийн ОУСХ-ээс санаачилан зохион байгуулсанаас хойш 2009, 2012, 2013 онуудад Улаанбаатар, Бээжин, Москвад тус тус зохион байгуулагдаад байгаа юм.

Мэдээ бичсэн Н.Ариунгуа

² <http://world.people.com.cn/n/2014/0531/c157278-25089552.html>